



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2016 оны 3 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2015 онд 16 аймгийн 114 суманд 354 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 45.649 га ой, 6.602.563 га хээр, нийт 6.6 сая га талбай өртөж, ард иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөнд 3.3 тэрбум, байгаль, экологид 59.4 тэрбум, нийт 62.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн онтой харьцуулахад түймрийн тоо 26%, учирсан хохирлын хэмжээ 2.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Түймрийн улмаас 1 хүн нас барж, 9 хүн түлэгдэж 67 айлын гэр, байшин, 151 өвөлжөө, хашаа, 7924 толгой мал, 22 автомашин шатжээ.

Цагдаагийн байгууллага 2015 онд гарсан 354 удаагийн ой, хээрийн гал түймрийн хэргийн материалыг шалгаж, 226 гал түймрийн эзэн, шалтгааныг тогтоон, 16 гал түймрийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, 6 хэргийн материалыг нэгтгэн 21.5 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, аянга, хуурайшилт зэргээс шалтгаалан гарсан үндэслэлээр 277 түймрийн зөрчлийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорын байгууллагад шилжүүлэн ажиллав.

Иймд 2016 онд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Батцэрэгт:

1.1. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилт, техник, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг;

1.2. Хавар, намрын хуурайшилтын улирал 4 дүгээр сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд Цаг уур, орчны шинжилгээний газраас сансрын "MODIS" хиймэл дагуулын зураг, цаг агаарын мэдээг шөнийн болон баяр, амралтын өдрүүдэд боловсруулан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг;

1.3. Түймрийн эрсдэл өндөртэй хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед Цаг уур, орчны шинжилгээний газрын цаг агаарт зориудаар нөлөөлөх улсын сүлжээг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн сумаар хангаж нөөц бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг;

1.4. Хавар, намрын хуурайшилтын улиралд ойн сангаас мод бэлтгэх, дагалт нөөц ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагаанд холбогдох хууль хяналтын байгууллагууд, байгаль хамгаалагчидтай хамтран хяналт тавьж ажиллах, ойн тухай хууль, дүрэм, журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэхийг;

1.5. Бүх шатны Засаг дарга нар, төр, аж ахуйн нэгж, байгууллагууд, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, ойн, нөхөрлөлүүд хавар, намрын улиралд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр сургалт дадлагыг зохион байгуулахыг;

Хоёр. Аймаг, нийслэлийн Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

2.1. Хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг илрүүлэх, шуурхай мэдээлэх, унтраах зорилгоор бүх шатны Засаг дарга нар ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран эрсдэл өндөртэй бүс нутагт хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэгийг байгуулж, иргэд болон байгаль хамгаалагч нарын оролцоотой урамшуулалт морин эргүүлийг ажиллуулах, тэдгээрийг автомашин, техник, холбооны болон хүнс, хувийн хамгаалалтын хэрэгсэл, шатахуунаар хангах, алслагдсан суурин айл, өрхүүдийг урамшуулах хэлбэрээр тогтмол мэдээлэл авахыг;

2.2. Ой, хээрийн гал түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний орон нутгийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангуулах, хил орчмын болон орон нутагт гарсан ой, хээрийн гал түймрийг нутаг дэвсгэрийн харъяалал харгалзахгүй шуурхай унтраах, түймэрт дайчлагдсан иргэд, хүн нэг бүрийн гар багаж хэрэгслийг шинээр бэлдэж нөөц бүрдүүлэх, дайчлагдан ажиллах иргэд, техник хэрэгслийн судалгаа, жагсаалтыг гаргаж, сургалт зохион байгуулахыг;

2.3. Бүх шатны Засаг дарга нар 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ний хооронд хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилахыг;

2.4. Аймаг, сум, багийн Засаг дарга нар гамшиг осол, объектын болон ой, хээрийн гал түймрийн үед ашиглах зориулалттай газар орны нэршил, айл, өрх, хүн ам, мал, амьтны тоог багтаасан ерөнхий байр зүйн зураг боловсруулан, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсээр хянуулж баталгаажуулахыг;

Гурав. Батлан хамгаалахын сайд,
Улсын онцгой комиссын орлогч дарга Ц.Цолмонд:

3.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх "МИ-171Е" нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгсэл хүрэлцэн очих боломжгүй хөвч, тайга, алслагдсан хээрийн бүсэд гарсан түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед

нисдэг тэрэг ашиглан түймрийн голомтод дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг шуурхай хүргэхийг;

3.2. Төв, орон нутгийн зэвсэгт хүчний анги, байгууллагын бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Онцгой байдлын газар, хэлтсүүдтэй хамтран хичээл, сургалт, дадлагын ажлыг зохион байгуулахыг;

3.3. Хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед Онцгой байдлын ерөнхий газартай хамтран эргүүлийн нислэг хийх, шаардлагатай тохиолдолд Ойн тухай хуулийн дагуу зэвсэгт хүчний албан хаагчдыг ой, хээрийн гал түймэр унтраах ажилд оролцуулж, шаардлагатай автомашин техник, багаж хэрэгслээр хангахыг;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
тэргүүн комиссар Р.Чингист:

4.1. Ой хээрийн гал түймрийн эзэн, холбогдогч, шалтгаан нөхцөлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, хариуцлага хүлээлгэх, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг улирал бүр Улсын онцгой комисст ирүүлэхийг;

4.2. Цаг агаарын хуурайшилтын “нэн аюултай”, “аюултай” зэрэгт хүрсэн үед орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран эргүүл, хяналт, шалгалтын цэг ажиллуулан, ногоон бүсэд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, автомашин, техникийн галын аюулгүй байдлыг хангуулахад хяналт тавихыг;

4.3. Аймаг, орон нутгийн цагдаагийн байгууллага ой, хээрийн гал түймэр гарсан тухай бүр түймрийн голомт дээр хүрэлцэн очиж онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээ, мэдээллийг харилцан шуурхай солилцож, хамтран ажиллахыг;

4.4. Аймаг, орон нутгийн цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хичээл, сургалт, дадлагын ажлыг зохион байгуулахыг;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
хошууч генерал Ш.Лхачинжавт:

5.1. Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр сургалт зохион явуулж, шаардлагатай техник, багаж хэрэгслээр бие бүрэлдэхүүнийг хангахыг;

5.2. Монгол Улсын хил орчим гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд шуурхай мэдээлж, гарсан гал түймрийг цаг алдалгүй унтраах, арга хэмжээг хамтран зохион байгуулахыг;

5.3. Монгол Улсын хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээх орнуудын хил дамнан гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг таслан зогсоох, үйл ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот албан хаагч, иргэдийг

хярбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тухай бүр зохион байгуулахыг;

5.4. Хил дамнан орж ирсэн болон хил давж гарсан ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээллийг Улсын онцгой комисс болон Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр тухай бүр хүргүүлэхийг;

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Т.Бадралд:

6.1. Ой, хээрийн гал түймрийг унтраах чиглэлээр мэргэжлийн анги, албадад сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр нийслэл, орон нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи төлөвлөгөөнд тодотгол хийхийг;

6.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нийт бие бүрэлдэхүүний ой, хээрийн гал түймрийг унтраах зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгааг гаргаж бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахыг;

6.3. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед мэргэжлийн анги, албад, орон нутгийн иргэдийг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд дайчилгаа явуулахыг;

6.4. Ой, хээрийн гал түймрийн голомтод олон хоног, удаан хугацаагаар ажилласан албан хаагчдын өдөр тутмын болон хөдөлмөр хамгааллын хувцасны эдэлгээний хугацааг харгалзахгүйгээр нөхөн хангалт хийхийг;

6.5. Төв, орон нутгийн Засаг дарга нарын боловсруулсан гамшиг осол, объектын болон ой, хээрийн гал түймрийн үед ашиглах зориулалттай ерөнхий байр зүйн зургийг хянаж баталгаажуулан үйл ажиллагаандаа ашиглахыг тус тус даалгасугай.

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг 2016 оны 6 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын Ажлын албанд ирүүлэхийг салбарын сайд, комиссын гишүүд, аймаг, нийслэлийн Онцгой комисс, холбогдох байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ШАДАР САЙД



Ц.ОЮУНБААТАР